

## ХИЙХ АЖЛУУДЫН ШАТ ДАРААЛАЛ

### Алхам 1



Захиалагчтай уулзаж, үнэ төлбөргүй өөрийн бүтээгдээнийг танилцуулна

### Алхам 2



Бизнес үйл ажиллагааны экспресс судалгаа хийнэ

### Алхам 3



Төлөвлөгөөт хуваарь гаргаж, үнэ өртөг тооцно

### Алхам 4



Төхөөрөмж болон програм хангамж суулгаж тохируулна

### Алхам 5



Хэрэглэгчдийг сургана

### Ашиглалт



Техникийн дэмжлэг туслалцаа үзүүлнэ

**1c** **FORUS** МОНГОЛИА

**Хаяг**  
Монгол улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн  
гудамж, Браухаус, 304 тоот

**Утас**  
7011-0175, 7000-0175  
**Э-шуудан**  
info@1c-forus.mn

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН  
НАЙРУУЛГЫГ 2016 ОНЫ 01-Р САРЫН 01-НЫ  
ӨДРӨӨС МӨРДӨЖ ЭХЛЭХЭД ЮУ ХИЙХ  
ХЭРЭГТЭЙ ВЭ?**

**Татварын хяналт шалгалтаар торгууль, зөрчилгүй хэрхэн гарах вэ?**

**Хэрхэн өөрийн хуучин худалдан авагчдыг хадгалан үлдэж шинийг татах вэ?**

**Борлуулалт болон хэрэгжүүлж буй маркетингийн үйл ажиллагааны талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллийг хэрхэн авах вэ?**

**НӨАТ СУУТГАН ТӨЛӨГЧИЙН  
ЗААВАРЧИЛГАА**

НӨАТ суутган төлөгчид 2016 оны 01-р сарын 01-ны өдрөөс эхлэн Татварын ерөнхий хуулийн 74 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ

**Хувь хүн болон хуулийн этгээдтэй хийсэн бүх борлуулалтыг харъялах татварын албанд бүртгүүлж, харин албан татвар төлөгчдөд тусгай загвартай худалдан авалтын баримтыг олгоно.**



## Хуулийн заалт:

### ХУУЛИЙН 4.1.20 –Т ЗААСНААР:

“Нэгдсэн систем” гэж Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн борлуулсан бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн баримтын мэдээллийг цуглуулах, боловсруулах, тайлагнах үйлдэлтэй системийг хэлнэ.

### ХУУЛИЙН 15.2.1-Т ЗААСНААР:

• Суутган төлөгч нь албан татвар төлөгчид сугалааны дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэн өгөх үүрэгтэй ба албан татвар төлөгч нь тухайн баримтыг бүртгүүлснээр НӨАТ-ын 20 хүртэл хувийн буцаалт болон сугалаанд оролцох эрх үүснэ.

• Суутган төлөгчөөр бүртгүүлээгүй хувь хүн, хуулийн этгээд нь сугалааны дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэн өгөх үүрэгтэй ба албан татвар төлөгч нь баримтыг бүртгүүлснээр сугалаанд оролцох эрх үүснэ.

### ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН 18.1.8-Т ЗААСНААР:

“Суутган төлөгч нь **Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин, хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин** хэрэглэх үүрэгтэй” гэж заасны дагуу худалдаа, үйлчилгээ эрхлэгч та төлбөрийн баримтыг НӨАТ төлөгчид олгохын тулд **хэрэглэгчийн систем /кассын систем/ - тэй** байх шаардлагатай.

## Шаардлага хангахын тулд юу хийх ёстой вэ?

### Програм хангамж худалдан авна



1С: Жижиглэнгийн худалдаа 8 – Жижиглэнгийн худалдааны үйл ажиллагааг татварын хуулийн дагуу тавигдах шаардлагад нийцүүлэн автоматжуулна

Програмын тухай дэлгэрэнгүй мэдээллийг дараах сайтаар орж, эсвэл утсаар холбогдож авна уу:

<http://1cmongolia.mn/catalog/1c/retail/>  
7011-0175, 7000-0175

### Татварын албанд бүртгүүлж, Системд нэвтрэх эрх авна

1. Дараах хаягаар орж бүртгүүлнэ <https://ebarimt.mn/posapi>

- Байгууллагын нэр, регистрийн дугаарыг заана
- Салбар бүрийн байршлыг сайт дээрх газрын зураг дээр тэмдэглэнэ

2. Цахим шуудангаар POS API татаж суулгах холбоос, зааврын хамт ирнэ (бүртгүүлснээс хойш 3-5 хоногийн дотор).

3. 1С: Жижиглэнгийн худалдаа програмыг 1С-Форус компанийн мэргэжилтэн ажилтны тусламжтай холбоно

### Худалдааны төхөөрөмжтэй холбогдоно

Дараах техникийн үзүүлэлтийг хангасан чек хэвлэх лазерын, эсвэл термо - принтер, POS-Систем:



- QR-код хэвлэх
- Чекийн өргөн нь 57 mm дээш
- Хэрэв чекийн өргөн 80 mm бага бол 203 dpi дээш, хэрэв чекийн өргөн 80 mm дээш бол 180 dpi дээш зөвшөөрнө
- Хэвлэх хурд 50mm/сек.\* их байна (Хурд сайн байх тусам чек хурдан хэвлэж олгоно)
- Дэмжлэг: Barcode 128C, 2D, 1D, GS1-13, UTF-8

\*Олон худалдан авагчтай худалдааны цэгийн хувьд чек хэвлэх 200 mm/сек дээш хурдтай принтер ашиглах нь зүйтэй.

## ! ИНТЕРНЕТ ХОЛБОЛТ

### Програм болон тоног төхөөрөмж нь дараах стандартын заалттай нийцэх ёстой:

MNS 5005:2015, Татварын нэгдсэн системд холбогдон ажиллах төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага  
MNS 6529:2015, Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримт, ерөнхий шаардлага